



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2024/114/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Бадрал

Утас: 91983443 Цахим хаяг: Badralts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ГАНБОЛД ТАНАА

2024.04.03 № 11134
танай _____-ны № _____-т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн улмаас мэдэгдэхүйц нөлөөний улмаас аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бэлтгэн нийлүүлэгч, гүйцэтгэгчидтэй тооцоо нийлж, авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, авлага өмнөх оноос өссөн, бараа материал, хөрөнгийн тооллого хийгээгүй, байгууллагын эзэмшилд байсан тээврийн хэрэгсэл бодитоор оршин байхгүй, шатахууны тооцоог бодоогүй, замын тооцооны хуудас хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ гаргасан, Засаг даргын захирамжид зааснаас илүү хөрөнгө зарцуулсан, санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй, 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 14 дүгээр зүйлийн 14.4.2-д "бүх

хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", 73 дугаар зүйлийн 1.2-д "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ", 2-д "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын тавдугаар зүйлийн 5.3-д "Засаг даргын захирамжийг үндэслэн санхүү, төрийн сангийн нэгж нөөц холбогдох арга хэмжээ, төслийн хэрэгжилтийн онцлог, үе шатны ажлын гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжилтийг олгоно.", Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан жишиг норм, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан маягт заавартай, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, тасалбар болголт, ангилал, толилуулга, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага өмнөх оны авлага барагдаагүй, авлагын үлдэгдэл 1,957.3 сая төгрөг байгаагаас 1,036.9 сая төгрөгийн авлага нь татаас санхүүжилтийн авлага байна. Тайлант онд 536.3 сая төгрөгийн өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэн 429.6 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Аудитын гол асуудал

Засаг даргын тамгын газар нь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 3 дэд хөтөлбөрийг шинээр баталж, 26 дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд 2023 онд хэрэгжсэн 29 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2023 онд Ховд аймаг сум багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, алсын хараа 2050, шинэ сэргэлтийн бодлого, Жангар өв соёлын наадам, налгар намар, эрт илрүүлгийн үзлэг оношилгоог эрчимжүүлэх зэрэг иргэд олон нийтэд чиглэсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 5 зорилтын хүрээнд 168 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаж, 93.8 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



X. Болдбаатар
Х.БОЛДБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,779,903,535.14</u>	<u>2,793,900,959.79</u>
33	АВЛАГА	506,395,024.22	1,300,473,177.82
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,017,411.00	4,238,892.07
33300	Татаас, санхүүжилтийн авлага	190,084,013.00	1,036,951,035.06
335	Бусад авлага	315,293,600.22	259,283,250.69
3351	Байгууллагаас авах авлага	315,293,600.22	259,283,250.69
34	УРЬДЧИЛГАА	595,831,600.00	660,238,600.00
34600	Урьдчилж гарсан зардал	595,431,600.00	659,838,600.00
3471	Урьдчилгаа тооцоо	400,000.00	400,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	400,000.00	400,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	218,147,707.92	304,942,356.97
354	Хангамжийн материал	197,085,886.97	288,883,236.97
35410	Бичиг хэргийн материал	3,515,000.00	1,046,700.00
35420	Аж ахуйн материал	610,000.00	145,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	22,257,150.00	23,737,650.00
35450	Барилгын засварын материал	84,611,600.00	75,633,400.00
35460	Хүнсний материал	-	97,000.00
35470	Бусад хангамжийн материал	86,092,136.97	188,223,486.97
35600	Мал амьтад	21,061,820.95	16,059,120.00
36	НӨӨЦИЙН БАРАА	459,529,203.00	528,246,825.00
36100	Барааны нөөц	66,584,203.00	29,762,325.00
36300	Тэжээлийн нөөц	391,801,000.00	498,484,500.00
36600	Бусад нөөц	1,144,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,170,303,547.20</u>	<u>5,511,262,512.75</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,170,303,547.20	5,511,262,512.75
392	Биет хөрөнгө	3,429,778,946.69	4,696,194,912.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,307,587,127.00	3,533,867,127.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(477,540,902.00)	(601,927,203.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	544,724,024.00	582,324,024.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(478,365,529.91)	(502,324,857.64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	565,861,943.90	843,798,246.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(337,244,351.46)	(406,650,277.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	251,251,697.52	258,606,697.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	(198,206,532.87)	(209,792,325.25)
39209	Зам, гүүрийн байгууламж	271,738,906.07	271,738,906.07
39210	Хуримтлагдсан элэгдэл	(130,853,483.00)	(135,038,149.76)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	29,289,700.00	29,289,700.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	(3,497,041.71)	(3,497,041.71)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	973,720,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	129,262,460.00	129,262,460.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(44,229,070.85)	(67,182,394.19)

393	Биет бус хөрөнгө	740,524,600.51	815,067,600.67
39301	Програм хангамж	17,886,115.00	17,886,115.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(17,429,114.49)	(17,886,114.33)
39303	Бусад биет бус хөрөнгө	740,067,600.00	815,067,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,950,207,082.34</u>	<u>8,305,163,472.54</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>16,954,695.75</u>	<u>79,508,000.16</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	16,954,695.75	79,508,000.16
413	Өглөг	16,954,695.75	79,508,000.16
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,848,545.74	3,468,754.15
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.01	0.01
4136	Бусад өглөг	15,106,150.00	76,039,246.00
41361	Байгууллагад төлөх өглөг	15,106,150.00	1,626,150.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	74,413,096.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,933,252,386.59</u>	<u>8,225,655,472.38</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,933,252,386.59	8,225,655,472.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,829,163,598.00	2,829,163,598.00
51101	Өмч: - төрийн	2,829,163,598.00	2,829,163,598.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,954,204,500.90	4,246,607,586.69
51210	Өмнөх үеийн үр дүн	1,954,204,500.90	1,954,204,500.90
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,292,403,085.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,149,884,287.69	1,149,884,287.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,950,207,082.34</u>	<u>8,305,163,472.54</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,520,832,762.71	10,026,199,090.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	409,290,240.71	1,694,121,880.26
120	Нийтлэг татварын бус орлого	409,290,240.71	1,694,121,880.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	409,290,240.71	1,694,121,880.26
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,209,065.59	8,954,020.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	388,081,175.12	1,685,167,860.26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,111,542,522.00	8,332,077,210.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	3,964,791,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	3,964,791,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,813,461,022.00	4,367,285,510.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,628,902,044.00	2,059,515,462.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,762,308.00	1,227,681,943.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	162,796,670.00	1,080,088,105.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,298,081,500.00	-

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,298,081,500.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,737,476,621.38	7,728,511,282.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,737,476,621.38	7,728,511,282.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,704,525,821.38	7,468,552,197.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,040,703,488.89	1,895,502,277.68
210101	Үндсэн цалин	587,409,874.64	1,123,950,854.94
210102	Нэмэгдэл	174,941,160.76	621,842,643.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,690,000.00	26,013,000.00
210104	Урамшуулал	23,107,372.00	100,823,648.00
210105	Гэрээт ажлын хөлс	239,555,081.49	22,872,131.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,478,998.17	223,128,502.77
210201	Тэтгэврийн даатгал	82,426,123.05	150,325,137.26
210202	Тэтгэмжийн даатгал	9,758,885.49	18,218,175.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,756,707.89	14,336,940.60
210204	Ажилгүйдлийн даатгал	1,908,089.50	3,465,708.85
210205	Эрүүл мэндийн даатгал	20,629,192.24	36,782,540.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	251,443,898.50	252,097,558.00
210301	Гэрэл, цахилгаан	41,858,751.50	41,691,297.15
210302	Түлш, халаалт	194,053,950.00	189,401,059.80
210303	Цэвэр, бохир ус	15,531,197.00	21,005,201.05
2104	Хангамж, бараа материалын зардал	159,262,314.96	255,496,976.17
210401	Бичиг хэрэг	16,130,300.00	17,616,005.00
210402	Тээвэр, шатахуун	131,733,114.96	220,473,301.17
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,492,900.00	16,810,970.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	560,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	206,000.00	36,700.00
2105	Нормативт зардал	344,400.00	2,275,052.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	344,400.00	2,275,052.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,157,936.90	6,132,842.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	634,936.00	180,000.00
210604	Урсгал засвар	2,523,000.90	5,952,842.00
2107	Томилолт, зочны зардал	39,466,150.00	78,644,534.00
210702	Дотоод албан томилолт	39,466,150.00	78,644,534.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,702,404.00	123,455,354.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,152,000.00	111,341,582.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,744,812.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,879,600.00	2,785,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	892,361.00	353,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	208,300.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,209,505.00	6,226,900.00
210807	Газрын төлбөр	860,638.00	959,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,049,966,229.96	4,631,819,101.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,773,440,322.32	4,365,111,485.57
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,078,243.00	4,410,000.00

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	275,447,664.64	262,297,615.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,950,800.00	259,959,084.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,944,800.00	131,225,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	300,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,611,500.00	126,667,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,333,300.00	4,257,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,000.00	128,733,784.83
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,000.00	128,733,784.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(216,643,858.67)	2,297,687,807.72
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	5,284,721.93
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	5,284,721.93
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(5,284,721.93)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(216,643,858.67)	2,292,403,085.79

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,829,163,598.00	1,149,884,287.69	1,954,204,500.90	5,933,252,386.59
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,829,163,598.00	1,149,884,287.69	1,954,204,500.90	5,933,252,386.59
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,829,163,598.00	1,149,884,287.69	1,954,204,500.90	5,933,252,386.59
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	2,292,403,085.79	2,292,403,085.79
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,829,163,598.00	1,149,884,287.69	4,246,607,586.69	8,225,655,472.38

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,684,061,867.59	9,100,385,761.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,605,065.59	8,954,020.00
120	Нийтлэг татварын бус орлого	17,605,065.59	8,954,020.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,605,065.59	8,954,020.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,605,065.59	8,954,020.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,666,456,802.00	9,091,431,741.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	3,964,791,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	3,964,791,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,368,375,302.00	5,126,640,041.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,789,486,074.00	2,059,515,462.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,762,308.00	1,227,681,943.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	557,126,920.00	1,839,442,636.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,298,081,500.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,298,081,500.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>5,684,061,867.59</u>	<u>9,080,885,761.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,684,061,867.59	9,080,885,761.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,461,377,054.59	7,781,273,041.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,002,965,673.57	1,884,092,739.00
210101	Үндсэн цалин	532,338,492.38	882,260,069.98
210102	Нэмэгдэл	175,184,176.73	744,101,259.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,266,542.97	29,935,396.08
210104	Урамшуулал	23,107,372.00	100,970,651.11
210105	Гэрээт ажлын хөлс	257,069,089.49	126,825,362.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,381,565.02	216,632,898.50
210201	Тэтгэврийн даатгал	84,381,831.23	151,946,454.38
210202	Тэтгэмжийн даатгал	8,461,276.29	10,861,407.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,288,472.37	14,242,861.26
210204	Ажилгүйдлийн даатгал	1,791,030.63	3,559,816.99
210205	Эрүүл мэндийн даатгал	19,458,954.50	36,022,358.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	284,678,400.00	284,977,700.00
210301	Гэрэл, цахилгаан	53,673,900.60	48,235,697.15
210302	Түлш, халаалт	202,651,500.00	201,913,059.80
210303	Цэвэр, бохир ус	28,352,999.40	34,828,943.05
2104	Хангамж, бараа материалын зардал	73,847,600.00	116,887,100.00
210401	Бичиг хэрэг	5,437,200.00	15,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	50,453,900.00	75,211,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,369,000.00	20,835,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	840,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,887,500.00	5,000,000.00
2105	Нормативт зардал	3,083,300.00	17,387,502.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,083,300.00	17,387,502.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,994,700.00	40,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,434,700.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	16,560,000.00	38,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	39,466,150.00	72,806,500.00
210702	Дотоод албан томилолт	39,466,150.00	72,806,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,009,300.00	222,233,260.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,982,000.00	200,229,900.00

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,333,300.00	3,200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,031,200.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	208,300.00	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,083,300.00	15,597,960.00
210807	Газрын төлбөр	871,200.00	1,045,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,876,950,366.00	4,925,755,341.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,873,617,066.00	4,917,755,341.61
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,333,300.00	8,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	222,684,813.00	1,299,612,719.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,594,800.00	133,927,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,611,500.00	126,667,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,983,300.00	7,260,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	190,090,013.00	1,165,684,819.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	190,090,013.00	1,165,684,819.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>19,500,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	19,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	19,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	19,500,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	19,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(19,500,000.00)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,984,791,700.00	3,845,011,935.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,965,291,700.00	3,825,511,935.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,820,023,800.00	3,691,584,035.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,862,281,900.00	1,860,775,525.56
210101	Үндсэн цалин	740,647,300.00	882,260,069.98
210102	Нэмэгдэл	747,889,800.00	744,101,259.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,204,000.00	29,935,396.08
210104	Урамшуулал	55,000,000.00	100,970,651.11
210105	Гэрээт ажлын хөлс	279,540,800.00	103,508,149.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	220,185,200.00	216,632,898.50
210201	Тэтгэврийн даатгал	153,141,900.00	151,946,454.38
210202	Тэтгэмжийн даатгал	11,510,800.00	10,861,407.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,808,700.00	14,242,861.26
210204	Ажилгүйдлийн даатгал	3,702,100.00	3,559,816.99
210205	Эрүүл мэндийн даатгал	37,021,700.00	36,022,358.68

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	284,977,700.00	284,977,700.00
210301	Гэрэл, цахилгаан	49,967,300.00	48,235,697.15
210302	Түлш, халаалт	201,251,500.00	201,913,059.80
210303	Цэвэр, бохир ус	33,758,900.00	34,828,943.05
2104	Хангамж, бараа материалын зардал	116,887,100.00	116,887,100.00
210401	Бичиг хэрэг	15,000,000.00	15,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	75,211,400.00	75,211,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,835,700.00	20,835,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	840,000.00	840,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	5,000,000.00
2105	Нормативт зардал	17,400,000.00	17,387,502.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,400,000.00	17,387,502.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,500,000.00	40,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	38,000,000.00	38,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	72,806,500.00	72,806,500.00
210702	Дотоод албан томилолт	72,806,500.00	72,806,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	93,035,400.00	90,633,260.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,630,000.00	68,629,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800,000.00	1,800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,200,000.00	3,200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,000,000.00	15,597,960.00
210807	Газрын төлбөр	1,045,400.00	1,045,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,111,950,000.00	990,983,549.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,103,950,000.00	982,983,549.11
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,000,000.00	8,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145,267,900.00	133,927,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	145,267,900.00	133,927,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	126,667,900.00	126,667,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,600,000.00	7,260,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,500,000.00	19,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,500,000.00	19,500,000.00
222001	Тоног төхөөрөмж	19,500,000.00	19,500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,984,791,700.00	3,845,011,935.17
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,964,791,700.00	3,836,057,915.17
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,964,791,700.00	3,836,057,915.17
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,000,000.00	8,954,020.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	8,954,020.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	5,126,640,041.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	5,126,640,041.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	4,089,689,005.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	23,317,213.44
210105	Гэрээт ажлын хөлс	-	23,317,213.44
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	131,600,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	131,600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,934,771,792.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,934,771,792.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,036,951,035.06
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,036,951,035.06
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,036,951,035.06
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	5,126,640,041.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,126,640,041.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,059,515,462.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,227,681,943.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,839,442,636.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 118,755.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 58,100.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- 3 ширхэг 58,100.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг данс бүртгэлд тусгаагүйг аудитын явцад залруулсан.

Залруулагдаагүй алдаа, зөрчил мэдэгдэхүйц нөлөөний улмаас аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй тул “Сөрөг” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 60,655.3 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 15,879.5 мянган төгрөгийн 2 зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 44,775.8 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1 Албан шаардлага

3.1.1 Шүүхийн шийдвэрээр 1 албан тушаалтанд 13,491.4 мянган төгрөгийн ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг төсвөөс төлсөн нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ.", 103.2-д "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна.", 103.3-д "Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Засаг даргын Тамгын газрын зарим тээврийн хэрэгслийг албан томилолт, хяналт шалгалтаар ажиллахаас бусад тохиолдолд тээврийн хэрэгсэл ашиглах эрхгүй албан тушаалтан ашиглаж 2,388.1 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Авлага, өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бэлтгэн нийлүүлэгч, гүйцэтгэгчидтэй тооцоо нийлж, авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулж, тайланд тусгах

3.2.2 Хөрөнгө, бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд бараа материал, хөрөнгийн тооллого хийгээгүй, тус байгууллагын эзэмшилд байсан тээврийн хэрэгсэл дутагдсан, бодитоор оршин байхгүй /энэ асуудал хуулийн байгууллагад шалгагдаж байна. / байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 14 дүгээр зүйлийн 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа

эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", 73 дугаар зүйлийн 1.2-д "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ", 2-д "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллого хийж, илүүдэл болон дутагдал гарвал цаг тухайд нь шийдвэрлэж, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

3.2.3 Шатахуунтай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2023 онд 36.8 сая төгрөгийн шатахууны тооцоог бодоогүй, замын тооцооны хуудас хөтлөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан жишиг норм, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан маягт заавартай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жишиг нормын дагуу жолоочийн тооцоог бодож байх, анхан шатны баримтгүй шатахууныг санхүүгийн тайланд тусгахгүй байх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

3.2.3 Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2023 онд санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл бүрэн хангагдаагүй гүйлгээ хийж, санхүүгийн тайланд тусгасан, зарим хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлийн тайлан, бусад баримтууд дутуу, Засаг даргын захирамжид зааснаас илүү мөнгө зарцуулсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын тавдугаар зүйлийн 5.3-д "Засаг даргын захирамжийг үндэслэн санхүү, төрийн сангийн нэгж нөөц холбогдох арга хэмжээ, төслийн хэрэгжилтийн онцлог, үе шатны ажлын гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжилтийг олгоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтийн тайланг бүрэн хангаж санхүүгийн тайланд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Аймгийн ЗДТГ	Үндсэн хөрөнгө бүртгээгүй	1	58,100.0	1	58,100.0			1	58,100.0				
		1	58,100.0	1	58,100.0			1	58,100.0				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Аймгийн ЗДТГ	Шатахууны тооцоо бодоогүй	1	36,814.4					1	36,814.4		
	Бараа материал, хөрөнгийн тооллого хийгээгүй, тус байгууллагын эзэмшилд байсан тээврийн хэрэгсэл дутагдсан, бодитоор оршин байхгүй	1	-					1	-		
	Бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлж авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй	1	-					1	-		
	Анхан шатны баримт, зарим хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлийн тайлан, бусад баримтууд дутуу, Засаг даргын захирамжид зааснаас илүү мөнгө зарцуулсан	1	7,961.4					1	7,961.4		
	Төрийн хэмнэлтийн хууль зөрчиж тээврийн хэрэгсэл ашигласан	1	2,388.1			1	2,388.1				
	Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг төсвөөс төлсөн.	1	13,491.4			1	13,491.4				
	ДҮН	6	60,655.3			2	15,879.5	4	44,775.8		

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1					1	
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1					1	

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР